



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/43

Рашаант сум

Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын
үзлэг тооллого явуулах бэлтгэл хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Аймгийн засаг даргын 2024 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн А/160 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг оношлогоо 2024 оны 4 дүгээр сарын 18, 19, 20-ны өдрүүдэд болох тул техникийн хяналтын үзлэг оношлогоо зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Б.Идэр (Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Энхжил (Сумын цагдаагын хэсгийн төлөөлөгч)

П.Цэндсүрэн (Татварын байцаагч)

С.Далай (Тээл багийн засаг дарга)

Б.Мөнхнасан (Талын -Ус багийн засаг дарга)

П.Мөнхтүвшин (Энх тал багийн засаг дарга)

Б.Баянбаатар (Цэнгэл багийн засаг дарга)

Д.Шинэбаяр (Их-Ац багийн засаг дарга)

2. Сум багт байгаа авто машин, чиргүүл, трактор, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн бүртгэл судалгааг гаргаж бэлтгэл ажил хангах, техникийн үзлэгт тээврийн хэрэгсэлийг бүрэн хамруулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Идэр)-т даалгасугай.

Сумын комисст даалгах нь:

а. Эзэмшигч нь өөр аймаг, сумын харьяалалд байгаа болон бусад аймаг хотын улсын дугаартай, улсын дугаар давхардсан тээврийн хэрэгслийн зөрчил болон татварын өр төлбөрийг арилгуулж, өөрийн аймгийн бүртгэл дугаартай болгон цэгцэлж үзлэг тооллогод бүрэн хамруулах

б. Тээврийн хэрэгслийн тооллого улсын үзлэгийн бэлтгэл ажлыг бүрэн хангуулж, чанартай явуулах талаар орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах.

в. Сум багт ашиглагдахгүй, хөдөлгөөнд оролцохгүй байгаа тээврийн хэрэгслүүдийн судалгааг гаргуулж улсын бүртгэлээс хасуулах

6706011073

г.Авто тээврийн хэрэгслийн өмчлөгч нь жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг харгалзан авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгт оруулах

3.Тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслийн техникийн үзлэгт тооллогод хамрагдаагүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн зогсоож, хяналт тавьж ажиллахыг цагдаагийн хэсгийн төлөөлөгч дэслэгч (Н.Энхжил)-д үүрэг болгосугай.

ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The signature is stylized and appears to be 'Б.Алтангэрэл'. The stamp is a red rectangular seal with some illegible text inside.

Б.АЛТАНГЭРЭЛ